



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар A/115

Бор-Өндөр сум

Хуулийн хэрэгжилтийг хангаж
ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.1, 70.1.2 дахь хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны А/350 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулж байгаатай холбогдуулан 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 2024 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 23⁵⁹ цаг хүртэлх хугацаанд Бор-Өндөр сумын хэмжээнд согтууруулах ундаа худалдан борлуулах, үйлчлэхийг, 2024 оны 06 дугаар сарын 23-ны өдөр урлаг соёл, үзвэр, спорт зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулахыг тус тус хориглосугай.
2. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэдээллээр хангаж, захирамжийн биелэлтийг хангаж ажиллахыг Бор-Өндөр сумын Сум дундын цагдаагийн хэлтсийн дарга (цагдаагийн дэд хурандаа Т.Энхбаяр)-д даалгасугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг засаг даргын орлогч (Х.Галбадрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ